

ОРЧИН ҮЕИЙН МОНГОЛЧУУДЫН ОРШУУЛГЫН ЁСОН ДАХЬ ШАШНЫ ЗАН ҮЙЛИЙН АСУУДАЛД

Э.Жигмэддорж (Доктор Ph.D)

Г.Идэрмаа (Докторант)

Түүхийн тэнхим, МУИС

Түлхүүр үг: Оршуулгын зан үйл, монголчуудын уламжлал, орчин үе, шашны зан үйл

Товч агуулга: Монголчууд хот суурин газар суурьших явдал нэмэгдсэн тэй холбоотой нийгмийн амьдрал, соёл түүний дотор оршуулгын ёс, хэлбэр, зан үйлд зарим өөрчлөлт орох болжээ. Үүний тодорхой жишээ нь Монгол улсын нийслэл Улаанбаатар хот юм. XX зууны дунд үеэс Улаанбаатар хот дахь оршуулгын асуудлыг эрхлэх тусгай байгууллагыг байгуулж, оршуулгын үйлчилгээг журамтай болгох арга хэмжээ авч хэрэгжүүлсэн түүхтэй.

Уг илтгэлд орчин үеийн монголчуудын оршуулгын ёсон дахь шашны зан үйлийн зарим асуудлыг товч өгүүлэхийг хичээсэн юм. Энэ дагуу Монгол улсын нийслэл хот дахь оршуулгын ёс, зан үйлийн нэлээд хэсгийг хариуцан гүйцэтгэж байгаа “Улаанбаатар Буян” ХХК-н баруун, зүүн буяны цогцолборт талийгаачийг хэрхэн үдэж буй зан үйл, үйлчилгээг жишээ болгон авч үзсэн болно.

1. Монголчуудын оршуулгын ёсны уламжлал ба өнөө үе

Монголын түүхийн эх сурвалж, хууль цаазын бичиг зэргээс үзэхэд, монголчуудын талийгаачийг оршуулах ёсон, зан үйл түүхэн цаг үеүүдэд хувьсан өөрчлөгдөж иржээ. Эртний монголчуудын хувьд булж оршуулах явдал түгээмэл байсан бол шарын шашин хүчтэй дэлгэрэхийн хамт нийтээр ил задгай оршуулдаг заншлыг дэлгэрүүлсэн ба 16-17 дугаар зууны үеэс ноёд, дээд лам нарыг чандарлан, чандрыг бумбанд хийж дээр нь суврага барин оршуулах, хүүрийг хатааж сүм бунхан барин хадгалах болсноор “Бумбат”, “Бунхант”, “Шарилт” гэдэг газар зүйн нэр гарсан байна .

Судлаачдын бичсэнээр нас барсан хүнийг хэрхэн оршуулах, хүндэтгэн нутаглуулах арга хэлбэр, зан үйл нь нь тухайн ард түмний шүтлэг бишрэл, зан заншил, ёс суртахуун зэргээс хамааралтай байдаг ажээ.

Монгол улсын Үндэсний Төв Архивт буй баримтаас үзэхэд XX зууны эхэн үед Их Хүрээ болон түүний ойр орчмын 15

газарт нас барсан эгэл ардыг их төлөв ил тавьж байсан бөгөөд уг үйлийг тусгайлан хариуцах хүнийг ясчин буюу яс баригч¹ хэмээн нэрлэж байв.

Ноёд, язгууртны хувьд ихэвчлэн далд оршуулах (булж оршуулах) бөгөөд “Ноёдын шарил оршуулсан газар”²-ыг хамгаалах үүрэг бүхий тусгайлан суулгасан өрх, ард байжээ. Бурханы шашны лам нар, хутагт, хувилгааны тухайд шарилыг чандарлан суварга бүтээхийн зэрэгцээ занданшуулан сүм дуганд залж байсан³ талаар архивын данс бичиг болон жуулчдын тэмдэглэл зэрэгт бичсэн байна.

1919-1920 онд Монгол сууж байсан И.Майский “Орчин үеийн Монгол (Автономит Монгол XX зууны гараан

¹ Х.Пэрлээ. Эртний монголчуудын үхэгсдээ оршуулж байсан зан үйлийн асуудалд. УБ., 1956. т.3

² Тухайлбал, “Хүрээнд хэн болох нь тодорхойгүй үхсэн хүмүүсийг ясчингаар зайлуулсан тухай” (МУУТА. ФМ-179, Д-1, Хн-975), “Хүрээний ойр тойроны 15-ний газар шалган байцааж, хүрээний газар нас барсан хүний ясыг ясчингаар зайлуулах зэрэг асуудлаар харилцсан нугалбар бичиг” (МУУТА. ФМ-33, Д-1, Хн-1770) зэргийг дурьдаж болно.

³ “Ноёдын шарил оршуулсан газрыг хамгаалж байсан ардуудын өрх, малын тоо бүртгэлийн данс” (МУУТА. ФТ-101, Д-2, Хн-4) г.м.

дээр)” бүтээлдээ тухайн цагийн оршуулах ёсны тухай өөрийн ажигласан сонин содон зүйлийг бичсэн нь ХХ зууны тэргүүн хагаст монголчуудын дунд ил тавих заншил түгээмэл байсныг илтгэнэ. Тэрбээр зохиолдоо

“Автономит Монголд нас барсан хүний оршуулга маш өвөрмөц байдалтай. Энэ бол эхлээд харахад европчуудад дээд зэргийн гайхамш төрүүлэх нэг монгол заншил юм. Гэхдээ Буддын сүсэглэлээр нас барсан хүний цогцсыг газарт булах ёсгүй, харин иувуу араатны идэш болгох учиртай. Ийм учраас монголчууд нас барсан хүнээ булшинд хадгалдаггүй харин хээр талд ил орхиж араатан амьтан, агаар салхиар үрэн таран хийлгэдэг ... Хүнгүй шахам газар хөдөөлүүлдэг болохоор талийгаачийг нутаглуулах энэ хэлбэрт ямар нэгэн онцгой, эвгүйрэх зүйл байхгүй. Томхон хот, сүм хийдийн газарт бол арай нарийн, жишээ нь 30000 орчим хүн байнга суудаг Өргөөд (Их Хүрээ) талийгаач харьцангуй олон тоотой учраас тэнд оршуулгад зориулсан тусгай були буй болсон байна. Энэ були гэдэг нь хотоос холгүй орших үхсэн хүнийг ил тавьдаг ерийн уулын энгэр бэлийг хэлнэ ... Өргөөгийн хутагт болон алдар нэртэй том лам нарын шарилыг занданиуулан олны мөргөлийн сүм дуганд байрлуулна.”⁴ гэх зэргээр ихэд нарийн бичиж тэмдэглэжээ.

Монголчуудын оршуулгын ёсон, зан үйлд холбогдох архивын данс бичиг болон жуулчдын тэмдэглэл зэрэг баримтаас харахад ХХ зууны дунд үе хүртэл Улаанбаатар хотын хэмжээнд нас барагсдийн шарилыг эрхлэн хариуцах тусгай байгууллага байгаагүй ажээ.

БНМАУ-ын СнЗ, МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчдийн тогтоолоор 1955 оны 7 сард Улаанбаатар хотод “Хүүр оршуулах товчоо”⁵ байгуулах шийдвэр гарсан нь хүн ам төвлөрсөн суурин газар дахь оршуулгын асуудлыг цэгцтэй болгох анхны алхам байв. Уг тогтоолд “Нас барагчдын хүүрийг оршуулах явдлыг журамтай болгох тухай” хэд хэдэн заалт орсон нь иргэдийн

эрүүл мэндийг хамгаалах, нас барагсдад хүндэтгэлтэй хандах, булшны газрыг харуул хамгаалалттай болгоход чиглэгджээ.

Улаанбаатар хотын хэмжээнд оршуулгын асуудлыг эрхлэн хариуцаж байсан тус байгууллага 1990-ээд оны эхэн хүртэл үйл ажиллагаа явуулсан байдаг.

1990 оны ардчилсан хувьсгалаар Монголд ардчилсан ёс тогтож, хүний шүтэх, бишрэх эрх чөлөөтэй болсоноор шашны олон урсгал нэвтэрч, үүнтэй зэрэгцэн оршуулгын төрөл, хэлбэр, зан үйл ч зарим талаар өөрчлөгдөв. Нийгэм, эдийн засгийн өөрчлөлттэй уялдан оршуулгын үйл ажиллагаа эрхлэх байгууллагыг 1992 оноос “Иргэдэд үйлчлэх Буян” компани болгон өөрчлөн зохион байгуулжээ.

Гэвч 1990-ээд оны сүүл гэхэд Улаанбаатар хотын хэмжээнд оршуулгын газар 1000 га газрыг эзэлж, нийслэл хотын өнгө үзэмж, экологи, эрүүл ахуй, сэтгэл зүйд сөрөг нөлөө үзүүлэх хэмжээнд хүрээд байв. Иймд энэхүү нөхцөл байдлыг харгалзан үзэж 2004 оны 4 сард НИТХ-ын тогтоол, Нийслэлийн засаг даргын захирамжаар “Иргэдэд үйлчлэх Буян” компанийг татан буулгаж⁶, “Улаанбаатар Буян” ХХК-ийг байгуулсан байдаг. Тус компани Монголд анх удаа шарил чандарлах үйлчилгээг бий болгосон бөгөөд орчин үеийн техник, тоног төхөөрөмж ашиглан уламжлалт соёл, зан үйлтэй хослуулан буяны ажлыг гүйцэтгэх болжээ.

“Улаанбаатар Буян” ХХК байгуулагдсанаас хойш Монгол улсын нийслэлийн хэмжээнд оршуулгын үйл ажиллагааг зохицуулах хууль эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр хэд хэдэн журам батлагдсан бөгөөд үүний үр дүнд оршуулгын газрын хамгаалалтын бүс бий болж, иргэдийн эрүүл, аюулгүй аж төрөх явдалд түлхэц болоод зогсохгүй нийгмийн сэтгэлд зүйд эерэг нөлөө үзүүлж байна⁷.

Монгол ардын мэргэн үгэнд “Орчлон ертөнцөд төрсөн бол буцах жамтай”

⁴ Нас барсан хутагт цорж хамба нарын шарилыг бумбанд хийх ба мөнгө гаргуулах тухай нугалбар бичиг (МУУТА. ФМ-171, Д-1, Хн-72), “Богдын шарилыг суваргалан хойт дүрийг тодруулах тухай тогтоол” (МУУТА. ФТ-179, Д-1, Хн-233) г.м.

⁵ И.Майский. Орчин үеийн Монгол (Автономит Монгол ХХ зууны гараан дээр). Орос хэлнээс орчуулсан Ц.Отхон. УБ., 2001. т.72

⁶ БНМАУ-ын СнЗ, МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчдийн 1955 оны 7 сарын 28-ны өдрийн 339/198 дугаар тогтоол (Хүүр оршуулах газар байгуулах тухай). Эх сурвалж: Монгол улсын Засгийн газрын архив.

⁷ 2004 оны 4 сарын 21-ний өдрийн НИТХ-ын 48 тоот тогтоол, Нийслэлийн засаг даргын 180 тоот захирамжаар “Иргэдэд үйлчлэх Буян” компани татан буутгаж, 2004 оны 6 сард Нийслэлийн өмчийн оролцоотой “Улаанбаатар буян” ХХК

хэмээнсэнчлэн эрдэнэт хүмүүнийг нас барахад сүүлчийн замд үдэх нь ариун бөгөөд буянтай, басхүү нэн хариуцлагатай ажил байдаг.

“Улаанбаатар буян” ХХК эртнээс уламжилж, өвөг дээдсээс даган мөрдөж ирсэн зан заншил, ёс журам болон орчин үеийн хөгжлийн чиг хандлагын дагуу буяны зан үйлийг гүйцэтгэж байна. Энэ дагуу Монгол улсын Үндэсний Төв Архив (МУУТА) болон Үндэсний Номын сан (МУҮНС) зэрэг газарт хадгалж буй монголчуудын оршуулгын ёсон, зан үйлтэй холбоотой судар, баримт материалыг эх хэрэглэгдэхүүн болгон ашиглаж байгаа юм.

Мөн монголчуудын оршуулгын соёл, зан үйлийн талаар гарсан эрдэм шинжилгээний ном бүтээл, судалгааны тайланзэргийн үр дүнг буяны зан үйлийг гүйцэтгэхэд чиглэл болгож байна.

Монголчуудын оршуулгын ёсон, зан үйлийг ажиглахад хорвоо ертөнцөөс халин одож буй нас барагсдын хойтын буян номыг дутуу үйлдэх, хүндэтгэлгүй хандах нь үлдэж байгаа хамаатан садан, төрөл төрөгсөдийн амьдрал ахуй бууран доройтох, ажил төрөл уруудах шалтаг болдог бол хүүхдүүд нь аав, ээжийгээ сайхан нутаглуулж, буяны үйлийг сэтгэлд хүртэл гүйцэтгэх нь өөдрөг сайхан амьдрах үндэс хэмээн үзсээр иржээ.

Архивын баримт зэргээс үзэхэд, монголчуудын оршуулгын ёсонд эгэл ард бол ил тавих, ноёд, язгууртныг далд оршуулах, хутагт хувилгаан, лам нарыг чандарлаж, занданшуулах хэлбэр зонхилж байсан бөгөөд нас барагсдийн шарилыг эрхлэн хариуцах тусгай байгууллага 1955 онд Улаанбаатар хотод анх байгуулагджээ.

2. Орчин үеийн монголчуудын оршуулгын чиг хандлага ба зан үйл

Өнөөгийн дэлхий олон улсад далд оршуулга болон чандарлан оршоох хоёр үндсэн хэлбэр зонхилж байна.

Дэлхий дахинд авч үзвэл оршуулгын чандарлах хэлбэр жил бүр өсөлттэй байгаа бөгөөд чандарлах зан үйл дэлгэрч буй шалтгааныг судлаачид дараах байдлаар тайлбарлажээ. Үүнд,

- Чандарлах нь оршуулах процессыг харьцангуй хөнгөвчилдөг
- Далд оршуулгатай харьцуулахад зардал багатай
- Улс орны дэд бүтэц, тэр дундаа оршуулгын газрыг эмх цэгтэй, зохион байгуулалт бүхий болгох давуу талтай
- Хөрсний бохирдлын асуудлыг шийдвэрлэхэд ач тустай

Газар ашиглалтын асуудлыг зүй зохистой болгоход тодорхой ач холбогдолтой зэрэг болно.

2016 оны байдлаар Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын бүсэд зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүй бүгд 20 гаруй оршуулгын газар байгаа бөгөөд нийт 1000 гаруй га газрыг хамарч байгаа юм.

Орчин үед монголчуудын оршуулгын ёсонд буддын шашны зэрэгцээ Бөөгийн шашин, Христос, Лалын зэрэг шашны нөлөө нэвтрэхийн хамт булж оршуулах, ил тавих, чандарлах зэрэг хэлбэр зэрэгцэн оршиж байна.

Монгол Улсын Бүртгэл, Статистикийн газрын мэдээгээр Улаанбаатар хотын хэмжээнд 1957-2015 оны хооронд 264.516 нас баралт бүртгэгдсэн байдаг. Улаанбаатар хотод нэг жилд дунджаар 6500-7500 хүн нас барж байгаагийн 50 орчим хувийг газарт оршуулж байна. Нэг шарилыг газарт оршуулахад ойролцоогоор 15-20м.кв талбай зарцуулдаг бөгөөд үүнээс 238516 хүнийг газарт далд оршуулсан гэж үзвэл 4.770.320м² буюу 477 га газар далд оршуулгад зарцуулагдсан тооцоо гарна. Энэ байдлаар оршуулгын газрын талбай хүрээгээ тэлж, түүнийг дагасан олон асуудал тулгарах нөхцөл үүсээд байгаа юм. Тухайлбал, оршуулгын газрын дэргэд айлууд олноор буух, ухвар мөчид зарим хүмүүс оршуулгыг ухах, хулгай хийх зэрэг нийгэмд хор уршиг бүхий үйлдлүүд гарах болов.

Улаанбаатар хэмжээнд 1957-2015 он хүртэл хийгдсэн далд оршуулга 265.000 гэж үзвэл 18894 м³ буюу 52000 тонн чулууг оршуулгын үйл ажиллагаанд ашигласан дүн гарна. Энэ нь Улаанбаатар хотын урд байрлах “Зайсан толгой” хэмээх толгойгоос гурав дахин том хэмжээтэй болж байна.

Түүнчлэн оршуулгын нэг хайрцаг

үүсэн байгуулагдажээ. Эх сурвалж: Нийслэлийн архив. “Улаанбаатар Буян” ХХК-ны танилцуулга.

хийхэд 2 метрийн урттай 12 ширхэг банз ордог бөгөөд Нийслэлийн хэмжээнд 1957-2015 он хүртэл хийгдсэн далд оршуулга 265.000 гэж үзвэл 529.032 ширхэг гуалин мод зарцуулагдсан дүн гарч буй.

Эдгээр судалгаанаас харахад далд оршуулга нь байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө их бөгөөд цөлжилт үүсгэх, гол мөрөн татрах, хөрсний бохирдол бий болгох, байгаль экэологийн тэнцвэрийг алдагдуулах нэг нөхцөл болдог ажээ.

Судалгаагаар янз бүрийн халдварт болон халдварт бус өвчнөөр нас барсан хүмүүсийг газарт оршуулсан тохиолдолд өвчний халдвар 60-70 жил ус, хөрс, агаарт хадгалагдаж, дахин өвчлөлийг шинээр үүсгэх магадлалтай байдаг ажээ. Энэ нөхцөлд дэлхийн ихэнх орнууд оршуулгын тухай хуулиараа зохицуулан чандарлан оршуулж халдвар тарах нөхцөлийг зогсоодог байна. Олон улсын оршуулгын холбооны албан ёсны цахим хуудсанд бичсэнээр Австрали, АНУ, БНХАУ, ХБНГУ тэргүүтэй дэлхийн 70 гаруй улс оршуулгын хуультай ажээ. Харин Монгол улсын хувьд өнөөг хүртэл оршуулгын тухай хууль батлагдан гараагүй байна.

Монголын түүхийн эх сурвалж, баримтаас үзэхэд язгууртан ноёд, ихэс дээдэс болон бурханы шашны томоохон хутагт, хувилгаан нарыг жанч халсны хойно чандарлах зан үйл үйлдэж байжээ. Энд зарим жишээг дурьдвал,

Чингисийн Алтан ургийн ноён Халхын Сэцэн хаан Норов 1650 онд нас барахад, биеийг чандарлан Алтан суврага бүтээж, тайлга, тахилгын ёслолыг XX зууны эхэн хүртэл гүйцэтгэжээ⁸. Энэ тухай Сэцэн хан Шолойн “Өмч хуваасан тэмдэглэл”-ийн холбогдох хэсгийг сийрүүлбэл,

“oom sayin amuGulang boltuGai / erte mongGol ulus-un noyan cinggis qaGan kemen / yabuju, tegUn-U Ur-e-yin Ur-e maqasamidi gegen / dalai secen qan Solui kObegUd-tUr-iyen ulus irgen-iyen Omci qubiyaju OgkUged, basa takiGsan / burqan SitUgen-iyen qamtu qubiyau OgkUi-dUr, ... / yisUdUger kObegUn ananda dalai jinung nadur / mOnggUn mayidari burqan nige, gegen qan-u / eke beki tayikeo-yin Saril jalaGsan altan / suburG-a nige, zangdan tamaG-a nige, qar-a / tuG nige, tUsi nige, tabun ijaGur-un / burqan-u kOrUg, langju UsUg-i mOnggU-ber / bUtUgejU torGan deger-e qadaGsan UsUg / bUri-yin GaduGur anu arba

arban mOnggUn / qadalG-a-tai malaG-a nige, mOnggUn ayaG-a / nige... / edeger jUyiles-i qayirlaju OgkUged, odu gegen / secen, Gal Golumta-ban kUliyelgekU kObegUn ken bolqu- / yi sinjilekUi-yin tula, olan kObekUd-tUr-iyen / arikin qayirlaju aGulGaGsan-dur bUgUdeger / soGtuju unaqui-dur anangda dalai jinung, / qan ecige-yin Gal Golumta-yi derelejU unaGsan-dur / mOn anangda dalai jinung-dur Gal Golumta-ban / kUliyelgejU egUrige ungtaraGaqu Ugei bolGabai...”⁸

хэмээгээд Сэцэн хаан өөд болсоны дараа шарилыг хайлж, галд эс шатсан нэгэн гарын шууны ясыг алтан суварганд залж, үүнийг эцгийн голомтыг хүлээлгэсэн хөвгүүн тахиж явбаас зохимой хэмээн Ананд далай жонон надад өгч тахиулсан буй гэжээ.

Монгол улсын Үндэсний Төв Архивын сан хөмрөгт Халхын шарын шашны тэргүүн Богд Жавзандамба хутагтын I-VIII дүрийн жанч халсан болон лагшин*⁹-г суварганд залсан, хойдын буянг хэрхэн үйлдэж байсныг улируулан шинжлэх цөөнгүй баримт үлдэж хоцоржээ⁹.

Монгол улсын Үндэсний Төв Архивт хадгалж буй XVIII-XX зууны эхэн үед холбогдох түүхэн эх баримтаас үзэхэд:

- Монголчууд шарын шашны тэргүүн болон хутагт хувилгаад ихэс дээдсийг жанч халсны дараа лагшинг занданшуулан сахиус шүтээн болгон сүм хийдэд залдаг байжээ. Халхын Богд Жавзандамба хутагтын шарилын сүм, суварга үйлдэн, үүрд шилжүүлэхгүй болгож, тахин шүтэх ёсон тэртээ XVIII зуунаас /1788 оноос/ тогтож, өнөөг хүртэл уламжлагдан иржээ.

- Хутагт, хувилгаан нарын лагшин, суваргыг бурхан шүтээн бүхий газар

⁸ “Улаанбаатар Буян” ХХК-ийн зүгээс “монголчуудын оршуулгын ёсон: уламжлал, өөрчлөлтийн асуудал” сэдвийн дагуу МУИС болон бусад мэргэжлийн байгууллагын эрдэмтэн судлаачдын оролцоотой олон нийтийн дунд хэд хэдэн судалгаа, санал асуулга явуулсан болно.

⁹ Монголын орчин үеийн оршуулгын ёсон, зан үйлийн талаар тусгайлан судалсан судалгааны бүтээл харьцангуй хомс юм. Энэ талаар дараах бүтээлээс дэлгэрүүлэн үзнэ үү. – Д.Эрдэнэбаатар. Монголчуудын оршуулгын зан үйлийн хувьсал өөрчлөлтийн тухайд. Түүхийн судлал. Том. XXXII. Fasc. 5. Улаанаатар, 2001. т.59-62; Г.Батнасан. Монгол оршуулга, уламжлал зан үйл. Улаанбаатар, 2005; Б.Отгонбаатар. Орчин үеийн монголчуудын оршуулгын зан үйл сэдвээр явуулсан хэргийн судалгааны тухай товч мэдээлэл. Угсаатан судлал. Том. XVII. Улаанбаатар, 2006; Хурцбилэг. Монголчуудын оршуулгын соёл. Өвөр Монголын Сурган Хүмүүжлийн Хэвлэлийн Хороо, 2005; Б.Отгонбаатар. Монголчуудын оршуулгын зан үйл (XX зуун). Улаанбаатар, 2009 гэх мэт.

бурхан бодисад, хутагт хувилгаадын адис жанлавыг оршоох тухайтад босгож хутагт хувилгаадын лагшинг оршоож нийтээр тахин шүтдэг байсан байна.

- Халхын шарын шашны тэргүүн VIII Богд болон түүний өмнөх дүрүүдийг жанч халсны дараа лагшинг хийд орны газар болон суварга шүтээн босгон тахин дээдлэх тухайтад заавал төр засгийн шийдвэрүүд гарч төр ёсны хэмжээнд хүндэтгэл үзүүлж байжээ¹⁰.

Ийнхүү хутагт, хувилгаадын лагшинг суварганд залан, дээдлэн шүэх явдал нь нийт Монголын ард түмэн амар амгалан оршин байхын ерөөл авшиг хүртээж буй хэрэг ажээ.

Түүхийн эх сурвалжийн мэдээнээс харахад чандарлах ёс нь Монголд эрт цагаас уламжлалтай бөгөөд XX зууны эхэн хүртэл байжээ. Харин 1920-иод оноос 1990-ээд он хүртлэх хугацаанд чандарлах зан үйл үлэмж багассан байна.

Монголчуудын хувьд жирийн иргэдийг чандарлах явдал бага байсан бөгөөд “Улаанбаатар Буян” ХХК-ны “Буяны төв цогцолбор” байгуулагдахаас өмнө олон нийтэд зориулсан чандарлах газар байгаагүй юм. Чандарлах газар бий болсон нь хотын хүрээ хэмжээ томрон тэлж, хүн ам олширсон, газар эдэлбэртэй нягт холбоотой.

“Улаанбаатар Буян” ХХК нь эдүгээ нийслэл хотын баруун, зүүн буяны цогцолборт талийгаачийг үдэх зан үйл, үйлчилгээг үзүүлж байна. Тус газрын чандарлах үйлчилгээ болон далд оршоох үйлчилгээний үйл явц нь тус бүр 16 хэсгээс бүрдэж байна.

Тус байгууллагын үйл ажиллагааны гол зарчим нь үйлчлүүлэхээр ирсэн хүн бүрт тайвшралаар угтаж, тал талын үйлчилгээг нэг дор цогц байдлаар үзүүлэх, зовж зүдэрч сэтгэл нь хямарсан хүмүүсийн сэтгэлийг тайтгаруулж, ухаарал сэхээрлийг хайрлахыг хичээн ажиллахад оршино хэмээн тодорхойлжээ. Энэхүү зорилтын хүрээнд эрдэмтэн судлаач, олон нийтийн болон шашны зүтгэлтэн, эгэл жирийн иргэдийн төлөөлөл оролцсон эрдэм шинжилгээ онол практикийн хурлыг тогтмол явуулж, тэдний үнэтэй санал зөвлөмжийг сонсож үйл ажиллагаандаа тусгасаар байна. Үүнд,

2007 онд “Монгол улсын оршуулгын үйл ажиллагааг олон улсын жишигт хүргэх нь”, 2014 онд “Монгол улс дахь оршуулгын зан үйлийн өнөө-ирээдүй” онол практикийн бага хурлыг тус тус зохион байгуулав. Хуралд оролцогчид:

- Монгол улсын оршуулгын үйлчилгээг боловсронгуй болгон олон улсын жишигт ойртуулахад төрийн болон ТББ, шашин, буяны байгууллага, иргэдийн хамтын ажиллагааг үр нөлөөтэй зохион байгуулах ажлын хэсэг байгуулан ажилласан нь үр дүнгээ өгч буй

- Оршуулгын зан үйлийн талаар иргэний боловсролыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх ажилд анхаарах нь иргэдийн сэтгэл зүйд эерэгээр нөлөөлж, хүлээн авах дагаж мөрдөх талдаа үр дүнтэй гэж үзсэн.

Монголчуудын уламжлалт зан заншил, шашин шүтлэгийн давуу талыг орчин цагийн өөрчлөлттэй уялдуулж чадвал бид оршуулгаас шалтгаалан үүсч байгаа олон асуудлыг шийдэх гарц болно хэмээн үзэж байна.

“Улаанбаатар Буян” ХХК нь төв байранд:

Үйлчилгээний захиалга авах, алтан сав нээх, буяны үйлчигээний байгууллагуудын үзүүлж буй үйлчилгээний болон Нийслэлийн хэмжээнд оршуулгын ажиллагаанд мөрдөгдөх эрх зүйн зөвлөгөө өгөх, мөн иргэдийн цаг завьг хэмнэх зорилгоор Нийслэлийн Бүртгэл Мэдээллийн газар, Нийслэлийн Нийгмийн Даатгалын Газар, Капитал банк, Буяны үйлчилгээ эрхэлдэг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран буяны үйлчилгээг нэг цэгээс, цогц хэлбэрээр хүргэж байгаа болно.

Буяны төв цогцолборт:

Буяны төв цогцолбор нь Улаанбаатар хотоос баруун тийш Сонгино хайрхан дүүргийн нутаг Баруун Турууны ам хэмээх газар байрлаж байна. Уг газар нь шарил хадгалах, чандарлах, салах ёс гүйцэтгэх, хойдын буян ном хурах, угаал үйлдэх хэсгээс бүрдэнэ. Салах ёс гүйцэтгэх хэсэг нь их, дунд, бага хэмжээний гурван танхимтай, үйлчлүүлэгчид өөрийн хүсэл сонирхолоор сонгох боломжтой юм.

¹⁰ Э.Жигмэддорж. Халх-Манжийн улс төрийн харилцаа. УБ., 2008.т.105

Тус шарил чандарлах газар нь тусгай сүмтэй бөгөөд уг сүмд талийгаачийн хойдын буян номын уншлага, шашны зан үйлийн ажлыг эрхлэн гүйцэтгэдэг. Талийгаачийг чандарлаад, салах ёс гүйцэтгэсний чандарлах газрын хойд талд орших суварганд байрлуулна.

Байнгын харуул хамгаалалт бүхий цэвэр тохилог орчин, уламжлалт шашны зан үйлийг олон улсын стандарт, орчин үеийн техник технологитой хослуулан шарил чандарлах үйлчилгээг тусгайлан бэлтгэсэн заал танхимд хүндэтгэлтэй гүйцэтгэн, чандарыг сүмийн гол танхимд хадгалах, суврага болон “Авид бурханы цэцэрлэгт хүрээлэн”-д ганцаарчлан залж бурхан бологсдын дурсгалыг үүрд мөнхжүүлэх, дүйцэн өдрүүдийн хурал хурах, ерөөл унших, зул өргөх гэх мэт хойдын буяны зан үйлийг шашны номд нийцтэй цогц үйлчилгээг үзүүлж байна.

“Авид бурханы цэцэрлэгт хүрээлэн”-г байгуулсан гол зорилго нь Бурхны шашны зан үйлийн дагуу талийгаачийн өөрийнх нь жилд ээлтэй мах бодиор оршоох боломжийг олгоход оршино. Оршуулгыг таван мах бодид оршоодог зан үйлийн уламжлалыг хадгалах, таван мах бодын хэсгийг тус цэцэрлэгт хүрээлэнд байгуулжээ. Одоогоор мод, чулуу, шороон хэсгийг байгуулаад байгаа юм.

Талийгаачийн ар гэрийнхэн хүсвэл төлбөр төлөөд сүм дотор байх тусгай шүүгээнд чандарыг хадгалуулж болох бөгөөд сүмийн хананд чандрыг кодлох ба талийгаачийн мэдээллийг архивлаж компьютерт хадгалж байна.

Суварга нь аравнай бүхий, адис жанлав оршсон эрдэнийн шүтээн хэмээн монголчууд үзсээр иржээ. Суварга босгох нь талийгаачийн хойноос хийж буй их буяны нэг бөгөөд ихэс дээдэс, хутагт хувилгаадаас гадна эгэл жирийн иргэдийн хувьд чандар сэлтийг суваргалах нь нарийн шүншиг зай тэргүүтнээр гэмийг арилгаж, сайн сайхан сэтгэлийг ар гэр, төрөл саданд хүртээж буй үйлдэл ажээ.

“Улаанбаатар Буян” ХХК нь олон түмний буян номын тухайд суварга бүтээхдээ монголчуудын олон зуун жил уламжилж ирсэн зан үйл, Үндэсний Төв Архивт хадгалж буй баримт сэлтийг эх үндэс болгож байгаа билээ.

Архивын баримт материалаас үзэхэд Суварганд бурханы ном судар сэлтийг залах бөгөөд суварганы сүншиг нь 1.Тухайлсан нэгэн хүний, 2.Нийтлэг хэмээх хоёр янз байна. Энд нэгэн баримтыг үзвэл, “Сайшаалт Ерөөлтийн 21-р (1816) он зуны сард IV дүгээр дүрийн шарилыг суваргалан Амарбаясгалант хийдийн газар залж бүхүй дор хамт залсан судар бурхан ба тахилын эд сэлтийг жагсаан бичсэн данс”-нд бичсэнээр Суварганы сүншигт оруулваас болох хэмээсэн юм нь:

“Далай ламын мутарын цан, мөн манай дөрөвдүгээр гэгээн мутарт удаан барьсан цан нэг хос, тахилын дун бүрээ нэг, мөн мутарт удаан барьсан дармар нүрээ, мөн зүүж хэрэглэсэн шагнан олгосон биу нэг, мутрын очир хонх нэг, Ёнзон лам Наваандэринлэйн дармар манжилагатай гүнчүгнэг, мөн арван таван лан есөн цэнгийн мөнгөн бумба нэг, шаазан сав нэг, бяцхан мөнгөн салам нэг, Хоёрдугаар гэгээний дэргэд тахих дор байсан бариултай тунгалаг сайн шин нэг, мөн гэгээний ах Ринчен жанжны эрдэнийн есөн суурьтай 200 лангийн үнэтэй хэмээх эрвээхэй хэвтэй хас эрдэнийн чулуу нэг, түвд мөнгөн зоос зургаа, орос мөнгөн зоос нэг, шар цагаан нэжгээд хадаг 2, дөрөвдүгээр гэгээний мутрын мөнгөн мандал, мөнгөн чандмань таван өнгөтэй уялага хадаг нэг”¹¹ гэжээ.

Талийгаачийг галд чандарлан оршоох зан үйлийг гүйцэтгэснээр 1.Ариун дагшин газруудад залах нөхцөл бүрдэнэ (талийгаачдыг Бурханы лагшин оршихуйн орон суварганд залах), 2.Сүнс дээшлэх (Гал мандалд хайлуулснаар тухайн хүний нэгэн насанд үйлдсэн элдэв нүгэл хилэнц шашны уншлага, зан үйлийн үрээр бүрэн арилж хойд насандаа сайн төрөлд төрөх замыг нээнэ), 3.Эдэлбэр газарт ач тустай, 4.Экологийн ач холбогдолтой (Газарт оршуулсан шарил 20 гаруй хорт хий, элдэв нян ялгаруулж, газрын хэвлийд тархдаг) байдаг.

Сүүлийн жилүүдэд Улаанбаатар хотод оршин суугч иргэдийн дунд явуулсан социологийн санал асуулгын судалгааны дүнгээс харахад чандарлах зан үйлийг дэмжих хандлага давамгайлж байна.

2015 онд Улаанбаатар хотын 9 дүүргийн 1000 хүнийг хамруулсан олон нийтийн санал

¹¹ Х.Пэрлээ. Дорнод Монголд XVII зуунд өмч хуваасан тэмдэглэлийн тухай. Монголын этнографийн асуудал (Studia Ethnographica). Tom. V. Fasc.2. УБ., 1977. т.40-50

асуулгын дүнгээс үзэхэд “Монголчуудын оршуулгын аль төрлийг дэмждэг бэ?” гэсэн асуултанд судалгаанд оролцогчдын хамгийн олон буюу 53.9% нь чандарлах зан үйлийг дэмжжээ. Үүнд, газарт оршуулахыг дэмжсэн 40.0%, чандарлах 53.9%, бунхлах 1.3%, ил тавих 3.6%, хариулаагүй 0.2% байна. Чандарлахыг дэмжсэн 539 хүний дотор 15-19 настай 1 хүн, 20-30 настай хүн 138, 31-40 настай 154, 41-50 настай 154, 51-60 настай 92, 61-70 настай хүн 15, 71-80 настай 4 хүн, 81-90 настай 1 хүн байна¹².

Судалгаанд оролцсон иргэд ирээдүйд оршуулгын газруудыг хэрхэн төлөвлөх тухайд хот суурин газрын хувьд, хотоос зайдуу тусгай зориулалтын газар (цогцолбор, төв г.м.) чандарлаж, цэцэрлэгт хүрээлэн байгуулах, хөдөө орон нутагт уламжлалт байдлаар эмх цэгцтэй газарт оруулах нь зүйтэй гэж үзжээ.

Харин 2000-2016 оны байдлаар нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд нас барагсдыг оршуулсан байдлыг ажиглахад чандарлах хэлбэр харьцангуй багассан үзүүлэлт гарсан байна.

Хүснэгт 1. Улаанбаатар хотын хэмжээнд нас барагсдыг оршуулсан байдал¹³

1-12 сар	Нас баралт	Чандарлаж оршуулсан		Бусад	
		Тоо	Хувь	Тоо	Хувь
2010	6400	2325	36.33	4075	63.67
2011	7123	2941	41.29	4181	58.70
2012	6874	3021	43.95	3853	56.05
2013	6358	2623	41.26	3735	58.74
2014	6674	2520	37.76	4127	61.84
2015	6570	2140	32.57	4430	67.43
2016	6445	1554	24.11	4891	75.89

Уг хүснэгтээс харахад, сүүлийн 7 жилийн байдлаар Улаанбаатар хотын хэмжээнд нэг жилд дунджаар 6000 гаруй хүн нас барсан байх бөгөөд үүнээс “Улаанбаатар Буян” ХХК нь 2012 онд хамгийн олон буюу 3021 хүнд чандарлах үйлчилгээ үзүүлсэн бол 2016 онд энэ тоо 1554 болж буурчээ.

Орчин үед оршуулгын газруудыг хэрхэн төлөвлөх тухайд хот суурин газарт чандарлах хэлбэрийг сонгох нь зүйтэй гэсэн

хандлага давамгайлж буй хэдий ч бодит байдал дээр хэрэгжих явдал харьцангуй бага байна. Үүнд, сүүлийн жилүүдийн Монголын эдийн засгийн үзүүлэлтийн бууралт болон шашин шүтлэгийн байдал нөлөөлж байгаа бололтой. Энд шашин шүтлэгийн байдлыг товч авч үзье.

Монгол улсын ШУА-ийн Философи, социологи, эрх зүйн хүрээлэнгээс 2008, 2010, 2012 онд явуулсан социологийн судалгаа болон 2010 оны хүн ам, орон сууцны тооллын дүнгээс үзэхэд монголчуудын дунд шашин шүтлэгийн тэр дундаа буддын шашин шүтдэг хүмүүсийн харьцангуй буурах хандлагатай байна. Үүнд,

2008 онд 21 аймаг, 126 сумын 4406 иргэдийн дунд явуулсан судалгаанд оролцогчдын 71.3 хувь нь буддын шашин, христийн шашин 4.3 хувь, ислам шашин 4.1 хувь, бөө мөргөл 1.9 хувь, 18.3 хувь нь аль ч шашин шүтдэггүй, 1 хувь нь бусад¹⁴ гэж хариулсан бол 2010 оны хүн ам, орон сууцны тооллогод анх удаа шашин шүтлэгийн байдлын тухай мэдээлэл авсан бөгөөд 15 ба түүнэйс дээш насны хүн амын дотор шашин шүтлэгтэй ба шүтлэггүй хэсгийн харьцаа 65.6:34.4 хувь¹⁴ байна.

2012 онд “Оператив” судалгааны төвөөс нийслэл Улаанбаатарын 6 дүүргийн 18-аас дээш насны 1000 хүнийг хамруулсан “Улаанбаатарчуудын шашин шүтлэгийн байдал” судалгаанд оролцогчдын 67.7 хувь нь буддын шашин шүтэж байхад 18-24 насны залуусын 12.3 хувь нь христ, 15.9 хувь нь бөө мөргөлийг шүтдэг гэсэн дүн¹⁵ гарчээ.

2015 оны судалгаанд хамрагдсан хүмүүсийн олонхи буюу 65,8% нь буддын шашинтан байна. Үүнд, Буддын шашин 65,8%, Христийн шашин 3,8%, Лалын шашин 0,8%, Бөөгийн шашин 13,8%, бусад шашин 2,1%, шашингүй гэж 13,7% нь хариулжээ.

Судалгаанд оролцогчид “Оршуулгын төрлийг хэрхэн сонгосон тухай” асуултанд хамгийн олон буюу 51.5% нь алтан савд заасны дагуу гэжээ. Үүнд, Алтан савд заасны дагуу 51.5%, хань, үр хүүхдүүд

¹² Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын 9 дүүргийн ард иргэдээс санамсаргүй түүврийн аргаар авсан “Судалгааны асуулга”-ын тайлан. 2015 оны 04 сар.

¹³ Уг хүснэгтийг “Улаанбаатар Буян” ХХК-ны 2016 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг үндэслэн гаргав.

¹⁴ “Соёлын үйлчилгээ-хүний хөгжилд” социологийн судалгааны дүнгээс. // Философи, эрхийн судлал. ХХШ боть. УБ.,2008

¹⁵ Хүн ам, орон сууц 2010 оны улсын тооллого: Үндсэн үр дүн. - Монгол улсын Үндэсний статистикийн хороо. УБ.,2011

18.5%, гэр бүлийн ахмад настан 17.7%, бурхан болоочийн захиас 5.0%, бусад 6.7%, хариулаагүй 0.6% байна. Ийнхүү судалгаанд оролцсон нийт хүмүүсийн тал хувь (51.5%) нь алтан савд заасны дагуу оршуулгын төрлийг сонгосон нь монголчуудын оршуулгын зан үйлд шашны тэр дундаа буддын шашны сургааль номлолын дагуу гүйцэтгэж байгааг илтгэнэ. Эдгээр 515 хүн нь шашин шүтлэгийн хувьд Буддын шашинтан 361, Христийн шашин 14, Лалын шашин 3, Бөөгийн шашин 80, бусад шашин 7, шашингүй 50 хүн байна.

Эдгээр судалгааны дүнгээс харахад Улаанбаатар хотын иргэдийн дунд буддын шашин шүтдэг хүмүүсийн эзлэх хувь буурч байгаа бөгөөд энэ нь монголчуудын соёл, зан үйлд өөрчлөлт орох нэг нөхцөл болж байна. Үүний тодорхой илрэл нь монголчуудын оршуулгын зан үйлд бурханы шашны зэрэгцээ Христ, Лал болон бусад шашны нөлөө нэвтэрч байгаа явдал юм.

И.Майский XX зууны эхэн үеийн монголчуудын талаар *“Дотоод сэтгэлийн эгэл хэвийн аливаа хүмүүсийн нэг адил монгол хүн үхлээс үл айна, түүнд их амгалан ажиггүй хандана. Ийм байхад түүнд шашин их түшиг болно”*¹⁶ хэмээн тэрээ 1920-иод онд бичиж байжээ.

Түүхэн эх сурвалжийн мэдээ болон судалгааны дүн нь монголчуудын өдөр тутмын амьдрал (Хүүхдэд нэр өгөх, сэвлэг үргээх, хурим найрын ёсон, оршуулга г.м.), соёл, зан заншилд шашны нөлөө харьцангуй их байдгийг харуулж байна. Иймд өнөө цагт монголчуудын соёл, зан заншлын нэг оршуулгын ёсыг уламжлал болон дэлхий нийтийн түгээмэл хандлагатай уялдуулах шаардлага тулгарч байгаа нь харагдана.

Сүүлийн жилүүдэд оршуулгатай холбоотой гарч буй нэг сөрөг үзэгдэл бол ухвар мөчид хүмүүс нас барагсдын булш бунханг ухах сүйтгэж байгаа явдал юм.

Монголчуудын оршуулгын ёс, зан үйл нь нарийн дэг жаяг бүхий бөгөөд хууль цаазын бичгүүдэд булш ухах буюу авс үзэгдэх, авсыг нээж яс үзэгдэх, ясыг гаргаж эвдэх зэрэг тохиолдол болгонд ял шийтгэл оноож байжээ. Тухайлбал, “Алтан хааны цааз бичиг”-т “Оршуулгын газраас эд авбаас амьд хүний эд юмыг авсан адил цаазтай” гэх мэтээр хууль эрх зүйн хувьд

эрт дээр үеэс мөрдөн ирсэн хатуу хуультай байсан боловч орчин үед энэхүү уламжлал зарим талаар алдагдаж, нийгмийн элдэв сөрөг үр дагавар учруулж байна.

Оршуулах зан үйлтэй холбоотой гарч байгаа олон тулгамдсан асуудлын нэг нь хууль, эрх зүйн шинэчлэлтэй салшгүй холбоотой юм. 2014 оны 6 дугаар сарын 9 өдрийн Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоол ёсоор “Нийслэлийн нутаг дэвсгэрт оршуулгын үйл ажиллагааг зохион байгуулах журам” батлагдсанаар Монгол улсын оршуулгын тухай хууль батлагдах эх үндэс болов.

Улаанбаатар хотын дахин төлөвлөлтийн асуудлыг нэн шаргуу ярьж байгаа энэ үед “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, 2030 он хүртэлх хөгжлийн хандлага” хэмээх төлөвлөлтийн баримт бичигт нийслэл хот тойрсон оршуулгын газруудын цаашдын төлөвлөлтийг тодорхой тусгах, хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тулгарч байна.

ДҮГНЭЛТ

Дээрх өгүүлсэн зүйлүүдээс харахад, 1990 оны ардчилсан хувьсгалын дүнд Монголд ардчилсан ёс тогтож, хүний шүтэх, бишрэх эрх чөлөөтэй болсоноор шашны олон урсгал нэвтэрч, үүнтэй зэрэгцэн оршуулгын төрөл, хэлбэр, зан үйлд зарим өөрчлөлт орж байна.

Орчин үед оршуулгын газруудыг хэрхэн төлөвлөх тухайд хот суурин газарт чандарлах хэлбэрийг сонгох нь зүйтэй гэсэн хандлага давамгайлж буй нь Улаанбаатар хотын хүн ам нэмэгдэж, хотжих үйл явц эрчимжиж байгаагийн нэг илрэл ажээ.

Монголын түүхийн эх сурвалжийн мэдээнээс харахад чандарлах ёс нь эрт цагаас уламжлалтай бөгөөд XX зууны эхэн хүртэл байжээ. Харин 1920-иод оноос 1990-ээд он хүртлэх хугацаанд чандарлах явдал мартагдах шахам болсон ба “Улаанбаатар Буян” ХХК-ны “Буяны төв цогцолбор” байгуулагдаж, анхны олон нийтэд зориулсан чандарлах газар бий болсноор оршуулгын энэ хэлбэр, уламжлалт зан үйл дахин сэргэжээ.

Сүүлийн жилүүдийн Монголын эдийн засгийн үзүүлэлтийн бууралт болон шашин шүтлэгт гарч буй өөрчлөлтөөс үүдэн нас барагчдыг чандарлах явдал харьцангуй багассан үзүүлэлт ажиглагдаж байгаа нь

16 Иргэдийн шашин шүтлэгийн байдал. <http://www.soinin.mn/news/culture/13629>

оршуулгын ёсыг уламжлал болон дэлхий нийтийн түгээмэл хандлагатай уялдуулах шаардлага буйг илтгэж байна.

Монголчуудын оршуулгын зан үйлийн уламжлал, өөрчлөлт, Улаанбаатар хотын нөхцөлд үүсч буй бэрхшээл, тулгамдсан асуудлыг шинжлэх ухааны үүднээс судлах, зүй зохистой шийдвэрлэх явдал өнөөгийн нийслэлийн төдийгүй Монгол улсын хөгжлийн чухал шаардлагын нэг болжээ.

НОМ ЗҮЙ

Архивын баримт

МУУТА. Ф-181, Д-1, Хн-11.
 МУУТА. М-9, Д-3, Хн-357, нугалбар-2.
 МУУТА. М-65, Д-2, Хн-95, нугалбар-1.
 МУУТА. М-31, Д-2, Хн-1277.
 МУУТА. М-86, Д-1, Хн-234.
 МУУТА. М-87, Д-1, Хн-188.
 МУУТА. Т-9, Д-1, Хн-2041.
 МУУТА. М-85, Д-2, Хн-652, нугалбар-5.
 МУУТА. Ф-1, Д-1, Хн-285
 МУУТА. Х-1, Д-1, Хн-289, х.168-169
 МУУТА. УТНОНББА. Х-4, Д-1, Хн-242, х.83, 86-87.
 МУУТА. УТНОНББА. Х-4, Д-1, Хн-520, х.45-47

Тогтоол шийдвэр

1. БНМАУ-ын СнЗ, МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчдийн 1955 оны 7 сарын 28-ны өдрийн 339/198 дугаар тогтоол (Хүүр оршуулах газар байгуулах тухай).
2. НИТХ-ын 2004 оны 4 сарын 21-ний өдрийн 48 тоот тогтоол, Нийслэлийн засаг даргын 180 тоот захирамж.

Судалгааны бүтээл

1. Батнасан Г. Монгол оршуулга, уламжлал зан үйл. Улаанбаатар, 2005
2. Отгонбаатар Б. Орчин үеийн монголчуудын оршуулгын зан үйл сэдвээр явуулсан хээрийн судалгааны тухай товч мэдээлэл. *Угсаатан судлал*. Том. XVII. Улаанбаатар, 2006;
3. Отгонбаатар Б. Монголчуудын оршуулгын зан үйл (XX зуун). Улаанбаатар, 2009
4. Хурцбилэг. Монголчуудын оршуулгын соёл. Өвөр Монголын Сурган Хүмүүжлийн Хэвлэлийн Хороо, 2005
5. Пэрлээ Х. Эртний монголчуудын

үхэгсдээ оршуулж байсан зан үйлийн асуудалд. УБ., 1956

6. Эрдэнэбаатар Д. Монголчуудын оршуулгын зан үйлийн хувьсал өөрчлөлтийн тухайд. *Түүхийн судлал*. Том. XXXII. Fasc. 5. Улаанаатар, 2001. т.59-62

ABSTRACT

Presently, Mongolian funeral practices are mostly guided by Buddhist lama, and have been being implemented under the religious theology. However, in modern society issues around traditional, evolving and currently executing funeral rituals of Mongolian funeral practices in the Ulaanbaatar city arising. Therefore, rapidly growing difficulties must be properly resolved through scientific evaluation, not only in capital city, but also for the development on Mongolia.

Due to the increasing urbanization of Mongolian nation, some changes occurring in the social life's and cultures, especially in the funeral practices, forms and ordinances. In the middle of XX century, the special organization was established to coordinate the funeral services and to measures to have funeral practice ordinances were taken.

In 1956 the Bureau of National Service of Ulaanbaatar city (Khuurorshuulahtovchoo (body burying bureau) was founded in order serve the citizens and it had been operating until the middle of 1990. In 1990 after the Democratic revolution, democratic tradition was established in Mongolia, which followed by excessive flow of religion, with some of the changes in funeral practices and ordinances. In 2004, by the Resolution of the Citizens' Representative Meeting of the Capital city and the Decree of the Capital city Mayor the "Ulaanbaatar Buyan" LLC was founded and have been servicing society with modern and advanced equipment, including the religious ordinances.

The presentation is mainly aimed to discuss the funeral services performed in the in west and east buyan complex of the "Ulaanbaatar Buyan" LLC, which is performing majority of the funeral services in the capital.